

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

1/27 дугаар зүйлийн 27.3.2 дахь заалт:

“27.3.2. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд Агаар орчны бохирдлын;”

2/27 дугаар зүйлийн 27.5.1 дэх заалт:

“27.5.1. Агаар орчны бохирдлын дэд хороо улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах асуудлаарх бодлого, зохицуулалтын болон хууль тогтоомжийн биелэлтийн асуудлыг;”

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн “27.3.2, 27.3.3, 27.3.4, 27.3.5” гэснийг “27.3.3, 27.3.4, 27.3.5, 27.3.6” гэж, “27.5.1, 27.5.2, 27.5.3, 27.5.4, 27.5.5” гэснийг “27.5.2, 27.5.3, 27.5.4, 27.5.5, 27.5.6” гэж тус тус өөрчилсүгэй.

Гарын үсэг